



"МОНОС ХҮНС" ХК-ИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН /маягт 1/

<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлагнах хугацаа	2023 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31 өдрийг хүртэл
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	"МОНОС ХҮНС" ХК /MFC/ улсын бүртгэлийн дугаар 9010002005, регистрийн дугаар 5568927, утасны дугаар 7777-3525
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хүнсний үйлдвэр
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-д бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	БДО аудит ХХК /2014-01-29/
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	408,850,429
Жилийн тайланг бэлтгэсэн, хянасан албан тушаалтны нэр	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү, Гүйцэтгэх захирал А.Отгондарь
1	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт
	Орлогын тайлан
	Өмчийн өөрчлөлтийн тайлан
	Мөнгөн гүйлгээний тайлан
	Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав
	Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав
	Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав
	Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2024 оны 03 дүгээр сарын 21-ний өдрийн хурлаар компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон хөндлөнгийн аудитын компани "БДО аудит" ХХК-ийн дүгнэлт зэрэгтэй танилцан хэлэлцсэн. Дээрх санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт зэрэг нь олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэл, аудитын холбогдох хууль тогтоомж, дүрэм, эрх бүхий байгууллагаас гаргасан зохицуулалтын журмын заалтын дагуу үнэн зөв илэрхийлж тайлагнасан болохыг хорооны гишүүд санал нэгтгэйгээр дүгнэсэн.
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/
	Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитыг БДО аудит ХХК хийсэн бөгөөд түүний дүгнэлтээр компанийн санхүүгийн байдлын тайлан, 2023 оны жилийн эцсийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ийн дагуу үнэн зөв илэрхийлсэн байна гэж тодорхойлсон.
2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл

2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Борлуулалтын орлого өссөн дүнгээр өнгөрсөн оноос 12%-ийн өсөлттэй. Шингэн хүнсний бүтээгдэхүүний борлуулалт голлох нөлөөг үзүүлэв. Цэвэр ашгийн хэмжээ өнгөрсөн оноос 9% өсч ашгийн маржин 11%-тай байсан. Өөрийн хөрөнгийн өгөөж 15.8%-тай.
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31-ны байдлаар Нийт хөрөнгийн 51%-ийг эргэлтийн хөрөнгө, 49%-ийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна. Эргэлтийн хөрөнгө 39 тэрбум.төг байгаа нь өнгөрсөн оноос 214% өссөн. Өнгөрсөн онтой харьцуулахад дансны авлага 10% өссөн бол бараа материал 36% буурсан. Бараа материалын хувьд өнгөрсөн оны эцэст импортын тээвэр, ложистискийн удаашралтай байдлаас шалтгаалан сав баглаа боодлын нөөцийг нэмэгдүүлсэн байсан бол энэ онд тээвэр хэвийн болсон учраас сав баглаа боодлын нөөцийг бууруулан ажилласан. Нийт эх үүсвэрийн 72%-ийг өр төлбөр, 28%-ийг эздийн өмч эзэлж байна.
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Шингэн хүнсний үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хуурай болон шингэн хүнсний үйлдвэрийг нэг байршилд нэгтгэх зорилгоор MFC 2.0 төслийг хэрэгжүүлэн төслийн гүйцэтгэл 90%-тай байна. Барилгын ажил дууссан бөгөөд тоног төхөөрөмжийн ажил 80%-тай үргэлжилж байна.
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 27.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь оны эцэст 27 тэрбумын зээл авсантай холбоотой. Тайлант хугацаанд 8.4 тэрбумын зээлийн үндсэн төлөлт хийсэн байна.
3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол, зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
		УИХ-ын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36-р тогтоол, Засгийн газрын 2023 оны "Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай" 63 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/140 тоот тушаал зэрэгт үндэслэн хүнсний болон хөдөө аж ахуйн үйдвэрлэлийг дэмжих зээл хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээлийг 2023-12-28-нд ХХБ-наас авч гэрээ хэлцэл хийж байгаатай холбоотой КТХ-ийн 76 дугаар зүйлийн 76.1.16-д заасан ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээнд их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгосон 3 тогтоолыг КТХ-ийн 88 дугаар зүйлд заасан шаардлагыг ханган, хуульд нийцсэн шийдвэрийг гаргасан болно.
4	Цалин урамшууллын мэдээлэл	
		Компанийн дүрэмд ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тодорхойлох, урамшуулал олгох саналыг боловсруулах бүрэн эрхийг ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо хариуцаж байхаар тусгасны дагуу хорооноос саналыг боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэдэг. ТУЗ-ийн гишүүдийн цалин улирал бүр олгох /ээлжит хурлын/ тогтмол цалин болон ээлжит бус хурлын оролцоонд үндэслэсэн цалин гэсэн бүтэцтэй. Компанийн гүйцэтгэх захирал, удирдлагын багийн гишүүдийг хөдөлмөрийн гэрээ, онцгой нөхцөлт хөдөлмөрийн гэрээнд тусгасан дүнгээр үндсэн цалин, гүйцэтгэлээс хамаарсан урамшууллын цалин гэсэн үзүүлэлтээр дүгнэж байна. Компани тайлант хугацаанд нийт 6,6 тэрбум төгрөгийн цалин урамшууллыг ажилтнуудад олгосон, үүнээс 436 сая төгрөгийн цалин урамшууллыг ТУЗ, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтанд олгосон байна.

5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
	<p>МУ-ын Компанийн тухай хуулийн 59.1, Монос хүнс ХК-ийн дүрмийн 6.1-д заасан компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулийн хугацаанд буюу 2024-04-20 өдөр танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Хуралд нийт 312 хувьцаа эзэмшигчдийн 306.4 сая ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцож, компанийн 2023 онд хийсэн үйл ажиллагаа, санхүүгийн тоон үзүүлэлт зэрэг ТУЗ, ГЗ нараас тавьсан тайлан, мэдээлэлтэй танилцаж, сонирхсон асуултаа асууж, зөвлөмж саналаа хэлэн, хэлэлцүүлж байгаа асуудлуудаар саналаа өгөх зэргээр хурлын үйл ажиллагаа өрнөсөн. Хурлын талаарх тайланг хуульд заасан хугацаанд СЗХ, МХБ зэрэг зохицуулах байгууллагуудад хүргэн тайлагнасан. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, засаглалын хувьд тэдний төлөөлөл болсон төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэх, СЗХ-оос батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилтийг хангах үүднээс хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцүүлэх батлуулсан. Мөн ТУЗ-ийн сайн засаглалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, бодлогын баримт бичиг зэрэг эрх зүйн бичгийг батлан, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад нээлттэй танилцах боломжийг олгох зорилгоор компанийн албан ёсны цахим талбарт байршуулсан. Мөн МХБ вэб хуудаст англи хэлээр санхүүгийн тайлангаа байршуулсан. ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Стратеги бизнес хөгжлийн хорооны дарга Ш.Алтанбагана өөрийн хүсэлтээр ТУЗ гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт ирүүлснийг ТУЗ хүлээн авч 2023-06-08 өдрийн хурлаар хэлэлцэн КТХ-ийн "77.5. ...чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно" гэсэн заалтыг үндэслэн ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлан Д.Энхтүвшинг түр томилсон. ТУЗ нь 2023 онд ээлжит 4, ээлжит бус 8 хурлыг танхим, цахим, эчнээ санал хураалтын хэлбэрүүдээр зохион байгуулж нийт 32 тогтоол батласан. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 9, Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо 3, стратеги бизнес хөгжлийн хороо 2 удаа тус тус хуралдаж компанийн гүйцэтгэх удирдлагын багт өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай зөвлөмж мэдээлэл, үүрэг даалгаврыг өгч ажилласан байна. Тайлант хугацаанд компани СЗХ-оос батласан "Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилтийн үнэлгээг 2 удаа хийж өөрийгөө үнэлэн, нотлох баримтын хамтаар СЗХ-ны компанийн засаглал, комплайнсын хэлтэст хүргүүлэн хянан баталгаажуулсан. Мөн ТУЗ-ийн хурлаар Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөр /2023-05-10 №04/05/, "ТУЗ үйл ажиллагааны журам"-д нэмэлт өөрчлөлт /2023-05-10 №05/05/, "Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам" /2023-05-10 №06/05/, Залгамж халааны бодлого /2023-08-31 №17/08/, Мэдээллийн үйл ажиллагааны журам /2023-08-31 №17/08/ зэрэг эрх зүйн баримт бичгийг батлан хэрэгжилтийг хангахаар зорин ажиллаж байна. Монос хүнс ХК нь МҮХАҮТ-ын нэрэмжит оны онцлох "Сайн засаглалыг хэрэгжүүлэгч Энтрепренер-2023" шагналыг хүртсэн юм.</p>
6	Зэх зээлийн эрсдэлийн мэдээлэл
	байхгүй
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	<p>"Монос хүнс" ХК нь хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Монголын Хөрөнгийн Биржид нээлттэйгээр арилжаалагддаг нийт 408,850,428 ширхэг хувьцаатай, 2012 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний үйлдвэрлэгч компанийн нэг юм. Нийт хувьцааны 70% буюу 286,195,300 ширхэг хувьцааг Л.Хүрэлбаатар (эцсийн өмчлөгч), үлдсэн 30% буюу 122,655,128 ширхэг хувьцааг олон нийт эзэмшдэг. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд зааснаар "Монос хүнс" ХК-ийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд ээлжит хурлыг жилдээ 1 удаа хуульд заасны дагуу хуралдуулдаг. Компанийн 2023 оны санхүү үйл ажиллагаа хэлэлцэх хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 сарын 20 өдөр Баянгол дүүрэг, Сонсголонд байрлах өөрийн Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийн байрандаа зохион байгуулж, хуралд ирсэн хувьцаа эзэмшигч нарт үйлдвэрээ танилцуулан хөрөнгө оруулалтын мэдээллийг бодитоор харах боломжийг олгон зохион байгуулсан. Мөн хурлыг Монос хүнс ХК-ийн фэйсбүүк групп зэрэг сувгаар шууд дамжуулалт хийн хурлыг мэдээллийг түгээж, хувьцаа эзэмшигчдээ мэдээлэл авах боломж нөхцлийг ханган ажилласан юм. Танхимаар хуралдсан хуралд нийт 408,850,428 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 306,476,853 ширхэг хувьцаа буюу 74,96%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр хүрэлцэн ирж, цахимаар хандаж оролцсон тул хурлыг хуульд заасан хүчин төгөлдөрт тооцож хуралдуулан, хурлаар хэлэлцэх асуудлуудыг шийдвэрлэж тогтоол шийдвэрийг гаргасан. Хурлаас гарсан шийдвэр болон хурлын үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг материалыг хуульд заасан хугацаанд Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлж ажилласан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг 2024-03-13 өдрөөр бүртгэхэд 12,880 хувьцаа эзэмшигчийн судалгааг ҮЦТХТ-өөс гарган ирүүлсэн юм.</p>

8	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</p>
	Тайланг өмнө тайлагнасан
9	Ногдол ашгийн мэдээлэл
	<p>2022-2023 онууд нь Монос хүнс ХК-ийн хувьд MFC 2.0 эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийг шинээр барьж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын жил байлаа. Энэхүү хөрөнгө оруулалтыг ЗГ-ын хөнгөлөлттэй зээл болон арилжааны банкны ногоон зээлийн эх үүсвэрээр шийдвэрлэсэн бөгөөд өндөр дүнтэй зээлийн хүүгийн дарамтаас хурдан гарах, санхүүгийн тэнцвэртэй байдлыг хангах, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнг үндэслэн 2024-02-19 өдрийн 30/02 тоот ТУЗ-ийн тогтоолоор "ногдол ашиг хуваариалахгүй байх" гэсэн тогтоолыг гаргаснаа 2024-04-20 өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулан тайлбар мэдээллийг өгсөн болно.</p>
10	<p>Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</p>
	<p>Хүн ардын эрүүл мэндийн төлөө, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компанийн хувьд олон нийт, ард түмэн рүү чиглэсэн олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж, бусад байгууллага, компанитай хамтран ажиллаж, ард иргэдэд мэдлэг олгох сургалт, зөвлөгөө, өдөрлөг зэрэг олон хэлбэрээр нийгэмд эерэг нөлөө үзүүлэхээр тогтмол хийж дадсан эмнэлэг, сувилал зэрэг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2023 онд хийсэн томоохон ажил бол эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд анхаарал хандуулж "Хэнэгтэй Монгол эр хүн" төслийг амжилттай эхлүүлж эрэгтэйчүүдийн тухай хэвшмэл ойлголтыг халах, өөрчлөх, нийгмийн нөлөөлийн төслийг амжилттай хэрэгжүүлж давхардсан тоогоор 22 сая хүнд хүрч бодитоор эрүүл мэнддээ анхаарал хандуулах ойлголтыг эрэгтэйчүүдэд төрүүлж чадлаа. "Экос" брэндийн зүгээс "Үрсээ устай үлдээе" уриалгыг дэвшүүлж "Моод" контенттэй хамтран орон сууцны айлуудад усаа хэмнэх жишгийг харуулсан нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэж 30 хүртэлх хувиар усаа хэмнэх бодит шийдлийг харуулж чадлаа. Хүүхэд багачуудын эрүүл мэндийг хамгаалах, аятай тухтай орчныг бүрдүүлэх уламжлалт цуврал ажлын хүрээнд энэ удаад хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ГССҮТ-ийн Түлэгдлийн эмнэлгийн, түлэнхийн нөхөн сэргээх хүүхдийн тасгийн тоглоомын өрөөг иж бүрэн засварлан, тохижуулж өгсөн. 2023 оны эхний хагаст иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сувиллын өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулж 1500 орчим амрагч, сувилуулагч иргэнийг хамрууллаа. Мөн 120 орчим мянган дагагчтай Монос Хүнс фэйсбүүк хуудсаараа дамжуулан "MFC ADVICE" нэртэй эмчийн зөвлөгөө видеог тогтмол хүргэн ажиллаж байна. Мөн Employee branding видео контенттой болоод байна</p>
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
	Овог нэр: Агваандорж овогтой Отгондарь
	Албан тушаал: "Монос хүнс" ХК-ийн Гүйцэтгэх захирал
	Гарын үсэг:  (Тамга/тэмдэг)
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
	Овог, нэр: Нацаг овогтой Цагаанхүү
	Албан тушаал: "Монос хүнс" ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
	Гарын үсэг: 

Сангийн сайдын 2012 оны
.....дүгээр тушаалын
.... дугаар хавсралт

Регистрийн дугаар:

5	5	6	8	9	2	7
---	---	---	---	---	---	---

Хаяг: Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 205/2

Шуудангын хаяг:

Утас: 77773525

Факс: 11-343525

Өмчийн Хэлбэр: ХК Төрийн ... Хувь Хувийн хувь



**"МОНОС ХҮНС" ХК
2023 ОНЫ 4-Р УЛИРЛЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар, өдөр	Гарын үсэг

Санхүүгийн байдлын тайлан

Монос хүнс ХК

(Аж ахуйн нэгжийн нэр)

2023 оны 12 сарын 31 өдөр

/төгрөгөөр/

	2022	2023
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	295,523,503.11	27,537,478,725.73
Дансны авлага	3,586,879,964.61	3,956,881,152.33
Татвар, НДШ - ийн авлага	45,608,166.32	2,174,902,729.74
Урьдчилж төлсөн татвар	45,608,166.32	2,174,902,729.74
Урьдчилж төлсөн даатгал	-	-
Бусад авлага	181,420,521.23	155,898,950.41
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	7,749,998,204.47	4,944,922,170.59
Бараа	2,323,729,763.47	1,085,059,770.83
Түүхий эд материал	4,822,245,917.85	3,230,096,097.33
Хангамжийн материал	279,446,865.40	431,434,616.73
Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
Агентад байгаа бараа	-	-
Замд яваа бараа	324,575,657.76	198,331,685.71
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	613,091,426.68	393,107,144.89
Урьдчилж төлсөн зардал	254,455,670.94	152,965,823.76
Урьдчилж төлсөн тооцоо	358,635,755.74	240,141,321.12
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус	-	-
Нийт Эргэлтийн хөрөнгө	12,472,521,786.41	39,163,190,873.69
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	22,188,419,475.85	37,399,888,885.06
Биет бус хөрөнгө	525,805,115.92	414,045,069.65
Биологийн хөрөнгө	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	70,222,475.21	76,129,571.34
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,250,587,704.55	283,210,938.04
Нийт Эргэлтийн бус хөрөнгө	24,035,034,771.53	38,173,274,464.09
Нийт ХӨРӨНГӨ	36,507,556,557.94	77,336,465,337.78

ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр	14,545,692,863.99	19,484,477,030.52
Дансны өглөг	1,270,084,023.62	1,079,640,204.43
Цалингийн өглөг	178,688,019.00	164,472,880.00
Татварын өр	1,707,273,428.59	1,688,054,915.53


НДШ-ийн өглөг	228,200,033.73	151,542,740.16
Богино хугацаат зээл	10,584,888,146.16	15,184,920,000.00
Зээлийн хүүгийн өглөг	105,935,104.01	249,479,832.44
Ногдол ашгийн өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	58,745,417.02	48,499,204.42
Нөөц өр төлбөр	150,427,648.00	211,013,841.60
Бусад богино хугацаат өр төлбөр	261,451,043.86	706,853,411.93
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бу	-	-
Урт хугацаат өр төлбөр	4,671,201,120.00	35,845,809,142.09
Урт хугацаат зээл	4,671,201,120.00	29,025,579,664.00
Нөөц өр төлбөр	-	6,449,500,336.00
Хойшлогдсон татварын өр	-	213,517,809.29
Бусад урт хугацаат өр төлбөр	-	157,211,332.79
Нийт Өр төлбөр	19,216,893,984.00	55,330,286,172.61
Эздийн өмч		
Өмч - Төрийн	-	-
Өмч - Хувийн	-	-
Өмч - Хувьцаат	2,318,181,926.76	2,318,181,926.76
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	6,835,733,063.19	6,835,733,063.19
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	410,914,484.64	2,508,104,274.29
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг	7,725,833,099.36	10,344,159,900.94
Нийт Эздийн өмч	17,290,662,573.94	22,006,179,165.17
Нийт ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	36,507,556,557.94	77,336,465,337.78

Гүйцэтгэх захирал

(А. Отгондарь)

Санхүү хариуцсан захирал

(Ц. Дэлгэрмаа)



Орлогын дэлгэрэнгүй тайлан

Монос хүнс ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

2023 оны 12 сарын 31 өдөр
/төгрөгөөр/

	2022	2023
Орлого үр дүн		
Борлуулалтын орлого (цэвэр)	28,216,577,528.49	31,676,949,027.58
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	15,928,710,967.46	17,203,846,543.85
Нийт ашиг (алдагдал)	12,287,866,561.04	14,473,102,483.73
Түрээсийн орлого	1,325,909.08	-
Хүүний орлого	-	11,025,158.14
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	73,083,093.93	35,530,930.13
Борлуулалт, маркетингийн зардал	5,100,559,378.38	6,711,229,370.61
Ерөнхий ба удирдлагын зардал	2,668,364,199.21	3,029,457,340.64
Санхүүгийн зардал	648,700,971.60	635,650,267.09
Бусад зардал	183,144,430.83	207,872,698.78
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(152,143,181.06)	(18,070,006.42)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	19,554,598.43	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,628,918,001.42	3,917,378,888.46
Орлогын албан татвар	441,581,110.69	437,088,692.03
Татварын дараах ашиг (алдагдал)	3,187,336,890.73	3,480,290,196.43
Зогсоосон үйл ажиллагааны татвар	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,187,336,890.73	3,480,290,196.43
Бусад дэлгэрэнгүй орлого	(41,027,234.13)	2,097,189,789.65
Нийт Орлого үр дүн	3,146,309,656.60	5,577,479,986.08

Гүйцэтгэх захирал

(А. Отгондарь)

Санхүү хариуцсан захирал

(Ц. Дэлгэрмаа)

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31 өдөр
/Төгрөгөөр/

Монос хүнс ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэгж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	451,941,718.77	0.00	0.00	5,315,169,830.50	14,921,026,539.22
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	451,941,718.77	0.00	0.00	5,315,169,830.50	14,921,026,539.22
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	3,187,336,890.73	3,187,336,890.73
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	-817,700,856.00	-817,700,856.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	-41,027,234.13	0.00	0.00	41,027,234.13	0.00
9	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	410,914,484.64	0.00	0.00	7,725,833,099.36	17,290,662,573.94
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	410,914,484.64	0.00	0.00	7,725,833,099.36	17,290,662,573.94
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	3,480,290,196.43	3,480,290,196.43
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	2,216,467,422.00	0.00	0.00	0.00	2,216,467,422.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	-981,241,027.20	-981,241,027.20
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	-119,277,632.35	0.00	0.00	119,277,632.35	0.00
17	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	2,508,104,274.29	0.00	0.00	10,344,159,900.94	22,006,179,165.17



Гүйцэтгэх захирал

(А. Отгондарь)

Санхүү харуулсан захирал

(Ц. Дэлэрмаа)

Мөнгөн гүйлгээний тайлан

Монос хүнс ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

2023 оны 12 сарын 31 өдөр
/төгрөгөөр/

2022

2023

Бүх цэвэр мөнгөн гүйлгээ

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Мөнгөн орлогын дүн (+)	2022	2023
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	29,663,716,558.08	34,015,031,813.20
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	27,400,613.58	4,616,680.48
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	15,860,208.38	13,860,764.51
Нийт Мөнгөн орлогын дүн (+)	29,706,977,380.04	34,033,509,258.19
Мөнгөн зарлагын дүн (-)		
Ажиллагчдад төлсөн	(3,870,389,516.40)	(5,008,558,949.11)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(1,067,812,750.00)	(1,705,388,907.54)
Бараа материал худалдан авахад төлсөн	(13,632,240,982.26)	(11,087,217,362.90)
Ашиглалтын зардалд төлсөн	(457,449,758.83)	(548,282,778.15)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл	(917,241,681.85)	(662,376,574.74)
Хүүний төлбөрт төлсөн	(986,519,574.52)	(2,859,718,765.74)
Татварын байгууллагад төлсөн	(2,281,896,780.18)	(4,205,520,615.02)
Даатгалын төлбөрт төлсөн	(112,117,496.00)	(108,065,510.15)
Бусад мөнгөн зарлага	(3,589,815,928.47)	(4,457,261,510.69)
Нийт Мөнгөн зарлагын дүн (-)	(26,915,484,468.51)	(30,642,390,974.04)
Нийт Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйл	2,791,492,911.53	3,391,118,284.15

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Мөнгөн орлогын дүн (+)	2022	2023
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,231,400.00	3,780,000.00
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буц	11,718,270.00	9,954,068.00
Хүлээн авсан хүүний орлого	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Нийт Мөнгөн орлогын дүн (+)	18,949,670.00	13,734,068.00
Мөнгөн зарлагын дүн (-)		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(11,222,732,950.61)	(10,620,045,027.54)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(14,704,000.00)	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төл	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	(28,500,000.00)	(6,000,000.00)
Нийт Мөнгөн зарлагын дүн (-)	(11,265,936,950.61)	(10,626,045,027.54)
Нийт Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны	(11,246,987,280.61)	(10,612,310,959.54)

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Мөнгөн орлогын дүн (+)		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн	17,777,825,374.13	43,853,517,924.13
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргасн	-	-
Төрөл бүрийн хандив	-	-
Нийт Мөнгөн орлогын дүн (+)	17,777,825,374.13	43,853,517,924.13
Мөнгөн зарлагын дүн (-)		
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(8,485,759,104.56)	(8,449,607,190.30)
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	(775,386,175.10)	(930,688,455.24)
Нийт Мөнгөн зарлагын дүн (-)	(9,261,145,279.66)	(9,380,295,645.54)
Нийт Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн	8,516,680,094.47	34,473,222,278.59
Валютын ханшийн зөрүү	(23,657,357.31)	(10,074,380.58)
Нийт Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	37,528,368.08	27,241,955,222.62
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний ү	257,995,135.03	295,523,503.11
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	295,523,503.11	27,537,478,725.73

Гүйцэтгэх захирал

(А. Отгондарь)

Санхүү хариуцсан захирал

(Ц. Дэлгэрмаа)

